



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2016-11-18 № 11

Асуулга тавих тухай

Монгол улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, гэмт хэрэг, тэр дундаа хар тамхины зохион байгуулалттай бүлэглэлийн гэмт хэргийн тоо нэмэгдэж байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэж байна.

Энэ талаар мэргэжлийн байгууллагуудаас өгч буй мэдээлэл, тооцоо судалгааны дүн зөрүүтэй байгаа ба хүчний байгууллагын албан хаагчдын мэдлэг, арга техник ч дутмаг байгаа билээ.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Танд дараахь асуулгыг тавьж байна.

Нэг. Монгол Улсын хэмжээнд хар тамхи, мансууруулах бодисын эргэлтэд тавих хяналт, өнөөгийн нөхцөл байдлын талаар;

Хоёр. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоо нэмэгдэж буй гол шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, гарсан хэрэг зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар;


Гурав. Төрийн болон төрийн бус байгууллагуудын гаргасан судалгааны дүн, тоон мэдээлэл зөрүүтэй байгааг хэрхэн шийдвэрлэх, энэ чиглэлээр дагнан ажилладаг байгууллагын албан хаагчдын мэдлэг, тоног төхөөрөмжийг хэрхэн сайжруулах, цаашид авах арга хэмжээний талаар;

Дөрөв. Манай оронд ургаж буй мансууруулах төрлийн үйлчилгээтэй ургамалд сүүлийн жилүүдэд устгал хийгдсэн эсэх, устгал хийхэд шаардагдах зардлын талаар;

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонгохыг Танаас хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Г.ЗАНДАНШАТАР